



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 1/31

Улиастай

Цол олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Билгийн тооллын XVII жарны “Хилэнт эх” хэмээх модон луу жилийн сар шинийн баярыг тохиолдуулан шагайн харвааны аймгийн “Хошой мэргэн”, “Гоц мэргэн” цолны болзол хангасан харваачдад цол олгосугай.

2.Цолны болзол хангасан харваачдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3.Аймгийн цол хүртсэн харваачдын шагналыг “Цагаан сарын харваа-2024” үйл ажиллагаатай хамтатган зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (П.Мөнхзаяа)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Н.Бямбадорж)-т даалгасугай.

ДАРГА  Г.ӨНӨРБАЯР

D/Захирамж docx

8109010137

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 сарын
01 өдрийн 31 захирамжийн хавсралт



ЦОЛНЫ БОЛЗОЛ ХАНГАСАН ХАРВААЧДЫН ЖАГСААЛТ

“Аймгийн гоц мэргэн” цолоор:

- Жигжжавын Мөнхдэлгэр (Эрдэнэхайрхан сум, “Жинст хайрхан” баг)
- Хаянхарваагийн Чойжилжав (Эрдэнэхайрхан сум, “Жинст хайрхан” баг)
- Бандийн Дашцэрэн (Яруу сум, “Чандмань” баг)
- Дамбийжанцангийн Хэнчбиш (Тэс сум, “Дөрвөн баян” баг)
- Аюурын Мөнхтэс (Тэс сум, “Дөрвөн баян” баг)
- Дугарын Гантөгс (Тэс сум, “Дөрвөн баян” баг)

“Аймгийн хошой мэргэн” цолоор:

- Энхжаргалын Золсайхан (Улиастай сум, “Жинст хайрхан” баг)
- Шуваагийн Вандандорж (Яруу сум, “Өргөн” баг)